

**“МОНГОЛЫН ХӨГЖИЛ ҮНДСЭНИЙ НЭГДЭЛ” ХК-ИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ**

2023 онь 04 сарын 30 өдөр

Дугаар 01

Улаанбаатар хот

┌ Санхүүгийн болон үйл ажиллагааны ┐
тайлан батлах тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9 дэх заалт, компанийн Хувьцаа эзэмшигчдийн 2023 оны 04 дугаар сарын 30-ний өдрийн ээлжит хурлын Тооллогын комиссын тогтоолыг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Компанийн 2022 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг баталсугай.
2. Компани 2022 онд ногдол ашиг хуваарилахгүй байхаар шийдвэрлэсэн ТУЗ-ийн тогтоолыг танилцуулсныг дурьдсугай.
3. Компанийн үйл ажиллагааг идэвхжүүлж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлд даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА



Ч.АМАРБААТАР

**“МОНГОЛЫН ХӨГЖИЛ ҮНДСЭНИЙ НЭГДЭЛ” ХК-ИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ**

2023 оны 04 сарын 30 өдөр

Дугаар 02

Улаанбаатар хот

┌ Компанийн үйл ажиллагаа, цар хүрээг нэмэгдүүлэх ┐
хөрөнгө оруулах болон нэмж хувьцаа гаргах төсөл батлах тухай

Монгол улсын Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.3 дахь заалт, компанийн Дүрмийн 7 дугаар зүйлийн 7.7.3 дахь заалт, компанийн Хувьцаа эзэмшигчдийн 2013 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн хурлын №3 тогтоол, 2023 оны 04 дугаар сарын 30-ний өдрийн ээлжит хурлын Тооллогын комиссын тогтоолыг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Хөрөнгө оруулах болон нэмж хувьцаа гаргаж монголын чөлөөт бүсүүдийг Евро азийн эдийн засгийн коридорын нэг цогц төсөл болгон хөгжүүлэх, Замын-Үүд Эрээний эдийн засаг хамтын ажиллагааны чөлөөт бүсийг хөгжүүлэх, төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх менежментийн компани болох, “Алтанбулаг, Замын-үүд чөлөөт бүс дамнасан цайны зам АН-3 хонгилын олон улсын авто тээвэр, ложистикийн цогцолбор”-ийн төсөл, Хөшигийн хөндийн чөлөөт бүсийн бүтээн байгуулалтын төслүүдийг дэмжиж, баталсугай.

ХУРЛЫН ДАРГА



Ч.АМАРБААТАР

**“МОНГОЛЫН ХӨГЖИЛ ҮНДСЭНИЙ НЭГДЭЛ” ХК-ИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ**

2023 оны 04 сарын 30 өдөр

Дугаар 03

Улаанбаатар хот

Г Компанийн үйл ажиллагаа, цар хүрээг нэмэгдүүлэх Г
хөрөнгө оруулах болон нэмж хувьцаа гаргах төсөл батлах тухай

Монгол улсын Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.3 дахь заалт, компанийн Дүрмийн 7 дугаар зүйлийн 7.7.3 дахь заалт, компанийн Хувьцаа эзэмшигчдийн 2013 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн хурлын №3 тогтоол, 2023 оны 04 дугаар сарын 30-ний өдрийн ээлжит хурлын Тооллогын комиссын тогтоолыг тус тус үндэслэн **ТОГТООХ** нь

1. Компанийн үйл ажиллагаа, цар хүрээг нэмэгдүүлэх хөрөнгө оруулах болон нэмж хувьцаа гаргах ажлыг эрчимжүүлэхийг Төлөөлөн удирдах зөвлөлд даалгасугай.
2. Компанийн зарласан боловч гаргаагүй 999, 950,000 /есөн зуун ерэн есөн сая есөн зуун тавин мянган/ ширхэг, 99,995,000,000 /ерэн есөн тэрбум есөн зуун ерэн таван сая/ төгрөгийн үнэ бүхий хувьцааг эргэлтэнд гаргахыг зөвшөөрсүгэй.
3. Компаний дүрмийн. 4.1-д өөрчлөлт оруулахыг баталсугай.
4. Хувьцаа гарагсантай холбоотой нэмэлт өөрчлөлтийг холбогдох байгууллагуудад бүртгүүлэхийг гүйцэтгэх захиралд даалагсугай.

ХУРЛЫН ДАРГА



Ч.АМАРБААТАР

**“МОНГОЛЫН ХӨГЖИЛ ҮНДСЭНИЙ НЭГДЭЛ” ХК-ИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ**

2023 оны 04 сарын 30 өдөр

Дугаар 04

Улаанбаатар хот

Г Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох тухай Г

Монгол улсын Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.7 дахь заалт, “Монголын хөгжил үндэсний нэгдэл” хувьцаат компанийн Хувьцаа эзэмшигчдийн 2023 оны 04 дугаар сарын 30-ний өдрийн ээлжит хурлын Тооллогын комиссын тогтоолыг тус тус үндэслэн **ТОГТООХ** нь:

Нэг. Кумулятив аргаар санал хураасан дүнг үндэслэн дараахь нэр бүхий 6 хүнийг Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн ердийн гишүүнээр сонгосугай.

1. Ч.Амарбаатар
2. Ж.Жаргалсайхан
3. Т.Наранбулаг
4. Н.Мөнх-Идэр
5. Д.Алтансүх
6. М.Отгонбаатар

Хоёр. Кумулятив аргаар санал хураасан дүнг үндэслэн дараахь нэр бүхий 3 хүнийг Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хараат бус гишүүнээр сонгосугай

1. Г.Төрбаяр
2. Н.Шагдарсүрэн
3. А.Ариунсайн

ХУРЛЫН ДАРГА



Ч.АМАРБААТАР